



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/549

Хэрлэн сум

“Талын түмэн адуу 2023” эвент
арга хэмжээ зохион байгуулах ажлын
хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Талын түмэн адуу 2023” аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Г.Мөнх-Эрдэнэ Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн

дарга: Т.Зулбаатар Соёл урлагийн газрын дарга

Гишүүд: Б.Мөнхжаргал Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Жавхланбаяр Батноров сумын Засаг дарга


Н.Нямсүрэн Орон нутаг судлах музейн дарга

Б.Баясгалан Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Аялал жуулчлалын албаны дарга

Э.Цэрэнбат Мөнх харилцаа ТББ-ын тэргүүн (зөвшилцсөнөөр)

2.Эвент арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөрийг нарийвчлан гаргаж, бэлтгэл ажлыг хангаж, өндөр түвшинд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ